

Тамирын Улаан хошууны нумын наалтан дээрх сийлбэр зургууд

Эрхэмжаргалын Билгүүн¹, Чинбатын Амарбилэг², Цагааны Төрбат^{2,*}

Товч агуулга: Энэхүү өгүүлэлд Архангай аймгийн Өгийнуур сумын нутагт орших Тамирын улаан хошуунд явуулсан хээрийн судалгааны ажлын хүрээнд 2017 онд малтан судалсан 36-р дурсгалаас илэрсэн нумын ясан наалт болон 2022 онд малтан судалсан 67, 74-р дурсгалуудаас илэрч олдсон нумын ясан наалтууд дээрх сийлбэр зургуудын судалгааны талаар өгүүлэх юм. Эдгээр нумын ясан наалтууд дээрх зургуудын талаар өгүүлэхдээ урьд өмнө нь олдсон буй нумын ясан наалтууд дээрх дүрслэлүүдтэй харьцуулан үзэж онцлог болон ялгаатай дүрслэлийг тодруулж харуулахыг зорилоо.

Түлхүүр үг: Нумын ясан наалт, зураасан урлал, хүннүгийн булш оршуулга

Удиртгал

Эртний нүүдэлчид олон мянган жилийн турш бэлчээрийн мал аж ахуй эрхэлж, тэрхүү нүүдлийн онцлогт тохирсон эдлэл хэрэглэл, өвөрмөц нүүдлийн соёл иргэншлийг цогцлоожээ. Анх чадварлаг хүн (*Homo Habilis*) эрхлэх аж ахуйгаа хялбарчлах арга замыг илэрхийлж байгальд элбэг тохиолдох чулуу, мод, яс зэргээр багаж зэвсэг хийж эхэлсэн бөгөөд хөгжлийн явцад тэдгээрийг боловсруулах арга зүй улам хөгжингүй болж яс, эвэр зэргийн хэлбэр дүрсийг өөрчлөн физик хэв шинжийг ашиглан модтой наан бэхэлж эвэр нум, харвуулын сум, гоёл чимэглэл зэргийг хийсээр иржээ. Үүний нэгэн жишээ бол нүүдэлчдийн нумын ясан наалт юм. Нумын ясан наалт буюу эвэр наалт нь амьтны эврийг хэлбэрт оруулан засаж нумын модон биед эвэр, шөрмөс зэргийг хамт нааж нумын уян хатан байдлыг нэмэн эвшээлгэхэд хагарах, хугарах зэрэг гэмтлээс сэргийлж нумыг бэхжүүлэн хэрэглэдэг байж.

Ийнхүү зүймэл нумыг өөд бологсдод дагуулан хойлоглох уламжлал эртний өвөг нүүдэлчдийн үеэс уламжлагдан оршуулгын зан үйлд хэвшжээ. Он цагийн уртад зүймэл нумын мод байгальд шингэж, нумын гичир, бариулын наалт, гуравч элэгний наалт зэрэг эвэр эдлэлүүд нь хадгалагдаж үлддэг. Хүннүгийн зүймэл нумын бүтэц нь дээд хэсэгтээ урт хос гичиртэй доод хэсэгтэй богино хос гичиртэй байжээ. Бариулын наалт хос нум хэлбэрийн бөгөөд зарим тохиолдолд хоёр үзүүртээ өргөн, голоороо нарийссан гуравч наалттай, тэгш бус хэмтэй. Хүннү нумын хэмжээний


талаар судлаач З.Батсайхан, бариулын наалтыг 27-36 см урт, өргөн хэсгээрээ 3,2-3,6 см, гичрийн наалт 30-45 см урт, дээд хэсгээрээ 1,5-2 см өргөн хэмээн тэмдэглэн, хоёр төрөл болгон ангилсан (Батсайхан 1992: 69–70) бол ОХУ-ын судлаач Ю.С.Худяков хүннү нумын хэлбэрээр нь дөрвөн төрөл болгон ангилсан байна. Судлаачид хүннү нум нь хөвчлөөгүй үедээ дунджаар 140-160 см урттай байсанд санал нэгдэж байна (Базарсүрэн 2000: 26–30; Батсайхан 1992: 71; Мөнхдэлгэр 2010: 13). Мөн энэ судалгаанд дурдвал зохистой зүйл бол ясан наалт гэх нэршлийн тухай юм. Ясан наалт уу? Эвэр наалт уу гэдэгт оновчтой хариулт өгөхөд e-DNA, ясны педтидын судалгаа хийх нэн чухал юм. Одоогийн байдлаар нумын наалтыг ямар амьтны яс, эврээр хийдгийг тодруулсан нарийвчилсан лабораторийн судалгаа хараахан үгүй байна. Эртний Ромын Поролиссум бэхлэлтэд гадаад туслах арми (*auxiliary*) байрлах дарангуй цэргийн сууринд хийсэн малтлагаар 51 ширхэг нумын гичрийн наалт илэрчээ (Legrand-Pineau et al. 2018). Тус судалгаагаар тэд бугын эврийг ашиглан түүгээр нумын эвэр гичир хийдэг байсан баримт мэдээлэл бий. Тухайн гичир нь хэлбэр болон хэв шинжийн хувьд Хүннүгийн үед хамаарах нумын гичиртэй ижил төстэй бөгөөд магадгүй эврээр хийсэн байх боломжтой мэт санагдана.

Бид энэхүү өгүүлэлд 2017 онд БСШУСЯ-ны тусгай захиалгаар хийгдсэн “Тамирын голын хүннүчүүдийн соёл” төслийн хүрээнд малтсан 36-р булшнаас илэрсэн морь унасан хүний дүрслэл бүхий эвэр наалт (Төрбат 2021: 221), мөн 2021 оноос эхлэн Монгол Банкны захиалгаар хэрэгжүүлсэн “Тамирын голын Хүннүгийн эрдэнэс” төслийн 2022 онд малтсан 67-р булшнаас илэрсэн тамгатай морь унаж ан гөрөө хийж буй хүний дүрслэлтэй бариулын наалт болон ханз, тамга бүхий гуравчны эвэр наалт, 74-р булшнаас

¹ Чингис хааны өв, соёлын хүрээлэн

² МУИС-ийн Нүүдэлчдийн археологийн хүрээлэн, ШУС, Археологи, антропологи, хүн ам зүйн тэнхим

* Холбоо барих зохиогч: turbat.ts@num.edu.mn



Зураг 1. Тамирын Улаан хошууны дэвсгэр ©Ц.Төрбат

илэрсэн гур, зур гөрөөсний дүрс бүхий бариулын эвэр наалтын (Төрбат et al. 2022) тухай танилцуулж, эртний нүүдэлчдийн зураасан зураглалын талаар авч үзэхийг зорилоо.

Эх хэрэглэгдэхүүн

Архангай аймгийн Өгийнуур сумын нутагт орших Тамирын Улаан хошууны Хүннүгийн оршуулгын цогцолбор нь Хүннүчүүдийн аж ахуй, нийгэм соёл, нийгмийн бүтэц зохион байгуулалтыг судлахад онцгой ач холбогдолтой, гайхамшигт дурсгалт газар билээ. Энэ дурсгалт газарт явуулсан олон жилийн хээрийн судалгааны үр дүнгээс бид зөвхөн нумын ясан наалт дээр сийлбэр зургийг авч үзэхийг зорив.

36-р булш. Өнгөн хөрсөн дээр 13 м бүхий голчтой цагариг хэлбэрийн дараастай. Эрт цагт тонох явцад бунхны тагийг бараг бүрэн эвдэж сүйтгэсэн байв. Модон бунхныг бүрэн цэвэрлэж гаргахад бунхны

төв хэсгийн зүүн захад авс, бунхан хоёрын дунд байх тахилгын хэсгийг дунд хэсэгт цөөн хэдэн мод хөндлөн тавьж тагласан байсан нь хөндөгдөөгүй үлдсэн нь 50×70 см орчим хэмжээтэй. Бунхны дотор талд малтлагын дараагийн үеийг эхлүүлж илэрч буй бүх олдворыг тухайн байранд нь үлдээж цэвэрлэхэд тонож сүйтгэх явцдаа авсны дотор талыг тэр чигт нь бусниулсан болох нь маш тодорхой болов. Бунхны зүүн хойд булангаас мөн бүсний хөөмөл чимэглэлийн үлдэгдэл, мөн буланд ваар савны бөөр хэсгийн хагархай илэрсэн ба дотор нь зэвэрч муудсан хавтгайдуу дөрвөлжин хэлбэртэй төмөр эдлэл илэрсэн нь төмөр артай, янгирын дүрслэл бүхий хөөмөл мөнгөн толгтой бүсний арал байв. Дэргэд нь хүрэн өнгийн ваар савны хагархайнууд илрэв (Төрбат 2021: 217–227).

Харин авсны гадна бөгөөд толгой талын тахилгын хэсгээс нэлээд олон тооны олдвор илрэв. Үүнд: чухам юу болох нь тодорхойгүй төмөр эдлэлийн үлдэгдэл,

төмөр амгайн үзүүр хэсгийн хугархай, төмөр зэв бүтэн нэг ба хагарч бутарсан нэлээд олон хэсэг бий. Түүнчлэн бүсний хөөмөл мөнгөн чимэглэлийн үлдэгдэл, нумын гичрийн ясан наалтын янгирын дүрсийг мөнгөөр товойлгон хөөмөллөсөн бүсний төмөр арал Зэвэрч хугарсан төмөр хутга, ишийг эврээр бүрж чимэглэсэн үлдэгдэл ба элэг, бариулын наалтын үлдэгдэл, төмөр хонх, төмөр артай амьтны дүрслэл бүхий бүсний хөөмөл мөнгөн чимэглэл, бүсний бололтой гуулиар хийсэн жижиг хос унжлага, хагас дугуйрсан хугархай төмөр эдлэлийн үлдэгдэл, өмнө нь илэрч байсантай ижил бүсний жижиг хөөмөл мөнгөн чимэглэл, дугуйрсан хавтгай төмөр эдлэлийн үлдэгдэл зэрэг эд өлгийн зүйлс илэрсэн болно.

Ийнхүү хэдийгээр эрт цагт тоногдож сүйдсэн боловч оршуулгыг 5 м гүнд 310×160 см хэмжээтэй модон бунхан дотор 210×85 см хэмжээтэй модон авсанд насанд хүрсэн нэг хүнийг оршуулсан байжээ. Авсны өргөн дунджаар 70 см ба өндөр нь хөл талдаа 30 см толгой талдаа 40 см орчим байв.

36-р булшнаас илэрсэн нумын ясан наалт: Хадгалалт муудсан хэд хэдэн хэсэг болж хугарсан. Хэмжээ хамгийн урт нь дунджаар 10 см. Хадгалалтын байдлаас хамааран бүрэн дүрслэлийг сэргээх боломжгүй болсон боловч бидэнд мэдэгдэж байгаа материал дээр тулгуурлан зургийг тайлбарлавал. Ерөнхий байдлаар нь дурдвал адуу унасан нэгэн хүнийг нум сум харваж буйгаар дүрсэлжээ. Хүнийг дүрслэхдээ нарийн зураасаар маш ерөнхий байдлаар тоймлон дүрсэлсэн. Хүний толгойг хагас зуван дугуй хэлбэрээр дүрсэлж нэг гарыг нумаас барьж буй мэт дүрсэлсэн байна. Харин нумыг дүрслэхдээ хагас дугуйруулан сумны үзүүрт гурван дэлбээт зэвийг дүрсэлсэн бололтой харагдана. Харин хүний цээж хэсгийг урт шулуун зураасаар тоймлон дүрсэлсэн ажээ. Адууны дүрслэлийн толгой хэсгийн ихэнх нь хугарч гэмтсэн байх ба зөвхөн морины хошуу хэсэг нь урт зураасны төгсгөлөөс хөндлөн зураас татаж ам

хамрыг илэрхийлэн дүрсэлсэн, адууны урд хөлийг нарийн хоёр зураасаар урагш сунган төгсгөл хэсэгт нь туурайг нь дүрсэлжээ. Адууны дэлийг зассан байдлыг харуулж богино нарийн зураасаар зүүн тал руу налуулан дүрсэлсэн бөгөөд хондлой дээрээс нь урт нарийн хоёр зураасыг төгсгөл хэсэгт нийлэх өнцгөөр зурж дэл сүүлийг илэрхийлжээ. Мөн адууны цээж болон хойд хөл хэсгийг нарийн дүрслэлгүй зөвхөн тойм маягаар урт зураасаар сараачин дүрсэлжээ.


67-р булш. Чулуун дараас бүхий цагариган хүрээний голч нь 600 см. Оршуулгыг үйлдэхдээ давхар авс хийсэн байна. Дотор талын авс буюу хүн оршуулсан авсны баруун урд булангаас бага насны бог малын 2 дал, чөмөг, сүүж, хавирга, тойг зэрэг яснууд илэрч байна. Хүн оршоосон авсны дотор талд хойд хананаас 25 см, толгой талын хөндлөвчнөөс 67 см зайтай төмөр эдлэлийн хэсэг мэдэгдэж байна.

Хойд хананы дагуух зайд нум тавьсан байна. Ясан наалтууд байрлалын дагуу үлдсэн бөгөөд нумын хэмжээ 168 см орчим хэмжээтэй. Нумын хамрын наалтын дээр 6 ширхэг ханз үсэг бичсэнээс гадна хацрын нэг наалтын дээр зураасан зураг зуржээ. Мөн тасалгаанд нумын дээд тал руу буюу хүний толгой хандсан зүгээс хадгалалт маш муу хазаарын амгай, төмөр зуузай илэрсэн.

Дотор талын авсанд хүнээ оршоож бөгөөд гадна, дотор авсны хөл, хойд ханануудын хоорондох зайг тахилгын хэсэг болгож байсан бололтой. Хүн оршуулсан авсыг 2 ширхэг өргөн банзаар таглаж хийсэн, түүний гадна, дотор авсыг дамнуулан хөндлөөш нь модоор хучиж тагласан байна. Гадна талын авсыг 4 ширхэг дүнз давхарлан, углуурагдаж хийсэн байна (Төрбат, Амарбилэг, Энхбаяр 2022: 17–21).

67-р булшнаас илэрсэн нумын ясан наалтууд

1-р ясан наалт. Харьцангуй сайн хадгалагдан үлдсэн нумын ясан наалт. Хэмжээ: 30,6 см урт, 4,1 см өргөн, 0,3 см зузаан. Эхний ясан наалтын дүрслэлийг



Зураг 2. Тамирын Улаан хошууны 36-р булшнаас илэрсэн нумын ясан наалтан дээрх сараачмал зураг (Төрбат 2021: 131)

тоймлон дурдвал: Анчнаас зугтан давхиж байгаа хуланг араас нь элдэн хөөж хоёрдох сумаа дөнгөж тавьсан морьтон харваачийн араас тайван даган явах нэгэн амьтныг /нохой?/ хамт дүрсэлжээ. Хуланг дүрслэхдээ хоёр чихийг соотойлгож, амыг хамхисан байдалтай их биеийг нарийн зураасаар тоймлон зурж цээжин дээд хэсэгт нэг сум, хондлой хэсэгт дахин нэг сум зоогдсон байдалтайгаар дүрсэлсэн бол урд хоёр хөлийг урагш жийлгэж, хойд хоёр хөлийг мөн урагш тэмүүлсэн байдалтайгаар дүрсэлсэн ажээ. Морьтныг дүрслэхдээ толгой болон их биеийн хэсгийг тоймлон зурснаас гадна нэг гараараа нумыг барьж нөгөө гар нь цээжин хэсэгт сумаа дөнгөж тавьсан мэт харагдахаар дүрсэлжээ. Адууны хувьд толгойн хэсгийг дүрслэхдээ чихийг соотойлгож амыг хамхисан, дэлийг урт нарийн зураасаар дүрсэлж, хондлой дээр урт нарийн зураасаар зурсан ямар нэгэн зүйлийг /хоромсого/ сийлсэн нь ажиглагдахаас гадна гуя нь дээр дэгрээ хэлбэрийн тамга мэт дүрсэл сийлжээ. Сүүлийг урт нарийн зураасаар, урд хөлийг хоёр цойлж буйгаар хөндлөн зураасаар зурж төгсгөл хэсэгт нийлүүлэн, хойд хөлийг мөн цойлж буйгаар урт нарийн зураасаар зурж туурай хэсгийг тод харуулжээ. Морьтны хойно дагаж буй амьтныг дүрслэхдээ чихийг соотойлгон, амыг хагас ангайлгаж хэлийг унжуулж, цээж хэсгийг нарийн зураасаар хөндлөн болон уртааш нь хэрж чимэглэсэн, урд хоёр хөлийг солбин алхаж буй мэтээр хойд хоёр хөлийг мөн адил дүрсэлсэн бол сүүлийг ганц хөндлөн зураасаар доош хандуулан дүрсэлжээ. Уг амьтны ар хэсэгт дүрслэлийн хувьд тодорхойгүй нэгэн сараачмал дүрслэл /мод, навч?/ байна.

2-р ясан наалт. Харьцангуй сайн хадгалагдан үлдсэн нумын ясан наалт. Хэмжээ: 29,4 см урт, 3,8 см өргөн, 0,3 см зузаан. Дүрслэлийн хувьд ямар нэгэн илэрхийлэмж нь тодорхой бус сараачмал дүрслэл.

3-р ясан наалт. Харьцангуй сайн хадгалагдан үлдсэн нумын хамрын наалт. Хэмжээ: 23,3 см урт, 2 захын өргөн 2 см, 0,1 см зузаан, голдоо 1,1 см өргөн, голдоо 0,3 см зузаан. Дээд хэсэгтээ дөрвөн ханз сийлсэн, ар талдаа шигүү сараачиж сийлсэн нумын хацрын наалт. Одоогоор энэ хамрын наалтан дээрх ханз үсгийг хараахан хөрвүүлж уншаагүй байна.

74-р булш. Гадаад зохион байгуулалтын хувьд өнгөн хөрс дээр мэдэгдэж байгаагаар цагариган хэлбэртэй чулуун дараастай 600 см голчтой.

Малтлагын 95 см гүнээс малын чөмөгт ясны хэсэг, зүүн урд хэсгээс модны нүүрс, хойд хэсгээс бод малын хүзүүний яс, зүүн урд хэсгээс бод малын яс зэрэг гарсан. Цаашлаад 140 см гүнээс ваар савны үлдэгдэл болон модны үлдэгдэл, шатсан модны судал маягийн зүйл баруун хойд зүгээс зүүн урд зүг рүү чиглэлтэй илэрлээ. Малтлагыг цааш үргэлжлүүлэхэд 158 см гүнээс ваар савны үлдэгдэл, 164 см гүнээс нэлээд хугарч эвдэгдсэн нумын гичрийн наалт, 170 см


гүнээс оршуулгын хөндлөвч банз гарсан.

Булшны хөндлөвч банзыг авсны дараа малтлагын ажлыг үргэлжлүүлэхэд авсны чиглэл зүүн урд зүгт 120° хэмд хандуулсан байв. Хүний яс анатомийн байрлалаа бүрэн алдсан байдалтай. Авсны баруун урд хэсгээс хүний далны болон хавирганы яс, зүүн хана дагуу мөн хавирганы яс, зүүн хана дагуу хавирга, шүд, шуу богтог яс эгмийн яс зэрэг гарлаа. Булшны дунд хэсгээс хавирга, хоёр дунд чөмгөний яс, сүүж, нуруу, хавирга, ууц, шилбэний яс зэрэг гарав. Хойлгын эд зүйлс булшны зүүн урд хэсгээс үүрэг зориулалт нь тодорхой бус, цагариган хэлбэртэй зэвд идэгдсэн төмөр эдлэл, булшны нүхний зүүн хана дагуу голлоод бүтэн ваар илэрсэн. Баруун хойд хэсэгт ваар савны хэсгүүд, зүүн хойд хэсэгт ваар савны ёроол тус ваарын ёроол дээр бог малын чөмгөний яс, засаж янзалсан ясан эдлэл илэрсэн. Булшны тонуул оршуулгын толгой хэсгээс эхлэн орсон нь тодорхой болсон бөгөөд хүний хөл хэсэгт буюу зүүн урд хэсэгт гурван ваар сав дагуулан тавьсны нэг нь эвдрэл гэмтэл багатай гарав. Авсны хашлаганы гадна баруун урд хэсгээс нумын гичир, дээрээ амьтны сараачмал дүрстэй хацрын наалт, хамрын наалт илэрсэн (Төрбат, Амарбилэг, Энхбаяр 2022: 36–40).


74-р булшнаас илэрсэн нумын ясан наалтууд

1-р ясан наалт. Харьцангуй сайн хадгалагдан үлдсэн нумын ясан наалт. Хэмжээ: 30,5 см урт, 3,5 см өргөн, 0,4 см зузаан. Дүрслэлийн хувьд хоёр гөрөөсийг давхиж буйгаар дүрсэлжээ. Бор гөрөөсний гурыг дүрслэхдээ эврийг тоймлон зурж, нүдийг дугуйруулан дүрсэлж хоншоорыг зууван битүү зураасаар илэрхийлжээ. Цээжин хэсгийг цэглэх аргаар цоохортуулан дүрсэлж, урд хоёр хөлийг урагш тэмүүлж цахилж буйгаар, хойд хөлийг мөн адил дүрсээр дүрсэлсэн бол сүүлийг богино оготор байдлаар дүрсэлсэн байна. Харин зурыг дүрслэхдээ хоёр чихийг соотойлгон нүдийг зууван дугуй дүрсээр илэрхийлж, цээжин хэсгийг цэглэх аргаар цоохортуулан дүрсэлж, урд хоёр хөлийг цахилж буйгаар, хойд хоёр хөлийг мөн адил дүрсэлсэн бол сүүлийг мөн адил оготор харагдахаар дүрсэлжээ.

2-р ясан наалт. Харьцангуй сайн хадгалагдан үлдсэн нумын ясан наалт. Хэмжээ: 29,5 см урт, 3,8 см өргөн, 0,4 см зузаан. Дүрслэлийн хувьд нэг гөрөөсийг дүрсэлсэн ажээ. Дээр дурдсан зурыг дүрсэлсэн дүрслэлийг бодвол харьцангуй болхидуу дүрсэлсэн байна. Хоёр чихийг нарийн зураасаар соотойлгон дүрсэлж, толгой болон их биеийг нарийн зураасаар дүрсэлсэн, урд хөлийг дүрслэхдээ хоёр нарийн зураасыг төгсгөл хэсэгт нийлэх мэтээр дүрсэлсэн боловч дүрслэлийг бүрэн дуусгаагүй байна. Хойд хөлийг дүрслэхдээ хоёр нарийн зураасаар зурж




Зураг 3. Тамирын Улаан хошууны 67-р булинаас илэрсэн 1-р ясан наалт (Төрбат, Амарбилэг, Энхбаяр 2022: 17–21)




Зураг 4. Тамирын Улаан хошууны 67-р булинаас илэрсэн 2-р ясан наалт (Төрбат, Амарбилэг, Энхбаяр 2022: 17–21)



Зураг 5. Тамирын Улаан хошууны 67-р булинаас илэрсэн нумын хамрын наалт /нэг талын буландаа ханз үсэгтэй/ (Төрбат, Амарбилэг, Энхбаяр 2022: 17–21)



Зураг 6. Тамирын Улаан хошууны 74-р булинаас илэрсэн 1-р ясан наалт (Төрбат, Амарбилэг, Энхбаяр 2022: 36–40)



Зураг 7. Тамирын Улаан хошууны 74-р булинаас илэрсэн 2-р ясан наалт наалт (Төрбат, Амарбилэг, Энхбаяр 2022: 36–40)

төгсгөл хэсгийг нийлүүлэлгүй орхижээ.

Дээр дурдсан нумын ясан наалтан дээр дүрслэгдсэн дүрслэлүүд нь зохиомжийн хувьд нүүдэлчдийн ан гөрөө хийж буй болон ан амьтныг дүрслэн харуулсан байна. Түүнчлэн бид тус нумын ясан наалтуудтай ижил төстэй байж болох материалуудыг доор харьцуулан үзэхийг зорилоо.

Харьцуулсан судалгаа

Энэ удаагийн судалгаандаа бид хүннүчүүдийн нумын бүтцэд чухал үүрэг гүйцэтгэдэг гичир, хацар, хамрын эвэр наалт дээр зураасан урлагийг ашиглаж ан амьтан, тамга тэмдэг, ханз үсэг зэрэг дүрсийг сийлэн дүрсэлсэн талаар авч үзэхийг зорьж байгаа билээ. Иймийн учир бид өнөөгийн Монгол Улсын нутаг дэвсгэрт явуулсан хээрийн судалгааны ангийн ажлын

үр дүнд илрэн олдоод буй нумын ясан наалтууд дээрх дүрслэлийг онцгойлон авч үзэхийн зэрэгцээ Тамирын улаан хошуунаас илрэн олдоод буй нумын ясан наалтуудтай харьцуулан судлахыг зорьсон болно.

Тухайлбал, Монгол Америкийн хамтарсан “Товийн Био-археологи” төслийн археологи антропологийн хээрийн судалгааны анги Дундговь аймгийн Дэлгэрцогт, Адаацаг сумдын нутаг Бага газрын чулуунд малтсан Хүннү булшнаас сийлмэл дүрстэй нумын эвэр наалт илэрсэн байна. Нэгдүгээр эвэр наалтан дээр салаа эвэртэй буга дүрсэлсэн бөгөөд биеийн хэсгийг болхидуу, хэвлийн хэсгийг дотогш нумарсан, доош татсан зураасаар үс дүрсэлсэн байж магадгүй, харин хөлийг нь урт шулуун зураасаар зурсан. Баруун хэсэгт адууг дүрсэлж, толгойн хэсэгт хазаар маягийн зүйл сийлж, мөн хөндлөн ба ташуу зураас зурж, туурайг хоёр зураасаар, хойд мөчийг нэг зураасаар төлөөлүүлжээ. Хоёрдугаар эвэр наалт дээр адууг хазаараа унжуулсан маягтайгаар дүрсэлжээ. Мөн нэгэн сонирхолтой дүрслэл нь хүн бөгөөд адууны зүүн талд урд дээлтэй дүрсэлсэн байна.

Үүнийг судлаач Ц. Амгалантөгс, Ч. Амартүвшин нар тайлбарлахдаа “Цулбуураас нь нэгэн хүн их хүч гарган татаж толгой руу нь ташуураар далайн цохих гэж буй дүрслэл байна” хэмээжээ. Баруун талд дүрс олон зураасыг татсан бөгөөд хэлбэр дүрсийг хэлэхэд хэцүү. Энэхүү дүрсийг мөн судлаачид тайлбарлахдаа “Нэгэн янгирыг дүрслэхдээ хоёр эврийг болон хүзүүг нь маш урт, их биеийн хэсгийг нэлээд доор, толгой болон хүзүүний хэсгээс салангид зүүн тийш харуулан дүрсэлснээс гадна их биеийг гадна толгойтой нь харьцуулахад жижиг бөгөөд сараачих маягаар дүрсэлжээ” хэмээжээ (Амгалантөгс, Амартүвшин 2005: 88–95).

Мөн Ховд аймгийн Булган сумын Авын хөх уулын Хүннүгийн үед холбогдох 20 дугаарт булшны малтлагаас мөн нумын ясан наалтад эмээлтэй морины дүрслэлийг сараачмал маягаар сийлсэн байна (Төрбат et al. 2015: 295–323) Энд хэдийгээр уг морины толгойг бүрэн гүйцэд дүрслээгүй боловч урт нарийхан хүзүүтэй, гуалиг нарийн биетэй, урт хөлтэй морийг хүзүүг нь шулуун сунгасан байдалтай чадварлаг



Зураг 8. Дундговь аймгийн Дэлгэрэх сумын нутаг Бага газрын чулууны Алаг толгойд малтсан хүннү булшнаас гарсан хэрэглэгдэхүүн (Амгалантөгс, Амартүвшин 2005: 94)



Зураг 9. Ховд аймгийн Булган сумын Авын хөх уулын Хүннүгийн үед холбогдох 20 дугаарт булшны малтлагаас гарсан нумын ясан наалт (Төрбат нар 2015: 318)



Зураг 10. Архангай аймгийн Хотонт сумын нутаг Хулхийн амны 21-р Хүннү булшнаас гарсан нумын ясан наалт (Очир, Чен 2015)

дүрсэлсэн байна. Хөлийн тавилт биеийн ерөнхий байдал зэргээс үзэхэд уг морийг хөдөлгөөн дунд дүрслэхийг хичээснийг мэдэж болно. Урагш налсан байдалтай жигд дэлнээс бид мориныхоо дэлийг орчин цагийн монголчуудын адил засаж тайрдаг байсныг харж болно. Мөн өтгөн урт сүүлнээс нь бид монгол морины хэв шинжийг харж болох бөгөөд Хүннүгийн үед алдаршсан “Баруун зүгийн мянган газрын гүйдэлтэй хүлэг” хараахан биш болов уу хэмээн дүгнэж байна. Доорх зургийн хамгийн сонирхолтой хэсэг нь өргөн уужим суудалтай эмээл ба хударга, хөмөлдөргийн дүрслэл юм. Энэ бол Хүннүгийн морины эмээлийн анхны бодит зураг дүрслэл мөн тул судалгааны өндөр ач холбогдолтой юм (Төрбат нар 2015: 318).

Архангай аймгийн Хотонт сумын нутаг Хулхийн амны 21-р Хүннү булшнаас 24-30 насны эрэгтэй хүний оршуулгаас нумын эвэр наалт илэрсэн бөгөөд гичрийн толгой хэсэгт дэгрээ тамганы дүрс бий (Очир, Чен 2015).

Хэлэлцүүлэг ба үр дүн

Дээр дурдагдсан олдворуудыг Архангай аймгийн Өгийнуур сумын Тамирын Улаан хошуунаас илэрсэн нумын ясан наалт дээрх дүрслэлүүдтэй жишин үзвээс хүн болон ан амьтныг дүрслэхдээ нарийн зураасан зургийн аргаар тоймлон дүрслэхээс гадна ихэвчлэн урагш тэмүүлсэн хөдөлгөөнд /dynamic/ байдлаар дүрсэлдэг ажээ. Нумын ясан наалтан дээрх дүрслэлийн хувьд төсөөтэй дүрслэлүүд байгаа хэдий ч голчлон зураасан зургийг хийх арга техник нь илүү ижил байна.

Тамирын Улаан хошуу болон Авын хөх уулын дээр дурдсан гурван ясан наалтан дээр адууг дүрслэхдээ урагш тэмүүлсэн хөдөлгөөнт /dynamic/ байдлаар дүрсэлсэн онцлог ажиглагдаж байна. Мөн 36-р болон 20-р дурсгал дахь адууны дэлийг зассан, харин 67-ийн адууны дэлийг засаагүй урт зураасаар хойш налуулан дүрсэлснээрээ ялгаатай ажээ. Мөн адууны эх бие болон хөлийг харилцан адилгүй дүрсэлсэн нь тухайн сийлбэрчний өөр өөрийн арга техникийг илэрхийлж байна.

Мөн 67-р дурсгалын ясан наалтын дүрслэлийн адууны гуя хэсэгт сийлэгдсэн дэгрээ тамгатай ижил төсөөтэй гичрэн дээрх дүрслэл Хулхын амны хүннү булшнаас илэрсэн байдаг. Хүннүгийн үеийн булш оршуулгын байгууламжаас гадна өөр бусад цаг үеэс эдгээртэй төстэй тамга тэмдэг түгээмэл олддог. Тухайлбал, Тэрэлжийн дөрвөлжний дээврийн нүүр ваар, Гол мод 2-ын 3-р булшнаас олдсон шагай дээрх нийлмэл тамга, Ховд аймгийн Үенч сумын Харгайтын бэлчир, Дунд Жаргалантын хадны зураг, Цагаан голын нийлмэл тамга зэргийг дурдаж болно. Мөн Сяньби болон Монголын эзэнт гүрний үеийн үеийн

их хаадын тамга, зоос, тэмдэгтүүд дээр дүрслэгдэн үлдсэн байдаг. Тухайлбал, Тулуйн удмынхан сэрээ тамга, Өгөдэйн угсааныхан дэгрээ тамгатай байжээ. Судлаачид дэгрээ тамгыг төрийн тамга, овог аймаг, эсвэл тодорхой угсаатны тамга гэж үздэг. Энэ утгаараа тус тамгыг тухайн овог аймгийн тамга тэмдгийг дүрсэлсэн гэж үзэж болохоор байна.

67-р дурсгалын ясан наалтан дээрх хуланг дүрслэхдээ адуунаас биеэр жижиг, урт соотон чихтэйгээр дүрсэлсэн бол анчны хойно дагаж буй нохой /Ми-гийн овгийн амьтан?/ -ны дүрслэлтэй харьцуулан судлах дүрслэл хараахан олдоогүй байна. Ханз дүрсэлсэн 67-р булшны хамрын ясан наалтыг хэв авч уншиж тайлах нэн шаардлагатай чухал олдвор хэрэглэгдэхүүн бөгөөд тус дүрслэл нь Хүннү-Хань улсын соёлын харилцааны судалгаанд чухал хэрэглэгдэхүүн болох юм.

Харин 74-р дурсгалын ясан наалт дээрх давхиж буй хоёр гөрөөсний их биеийг цэглэж цоохорлон дүрсэлсэн нь өөр бусад нумын ясан наалтууд дах дүр дүрслэлийн хэрэглэгдэхүүнд одоогийн байдлаар тохиолдоогүй өвөрмөц дүрслэл ажээ.

Эцэст нь нумын наалт дүгнэн үзэхэд дээр дүрслэгдсэн сийлбэрүүд хоорондоо яг ижил төсөөтэй, утга агуулгатай гэж үзэхээс илүүтэйгээр анчин гөрөөчид өөрсдийн ур чадвар, ан ав, овгийн тамга тэмдгийг тухайн нумын эзэд өөрсдөө сийлбэрлэн үлдээсэн хэмээн үзэж болохоор байна.

Abstract

Engraved images on bow plates from Tamiryn Ulaan Khoshuu, Central Mongolia

Erkhemjargal Bilguun, Chinbat Amarbileg and Tsagaan Turbat

This article presents the line-art imagery engraved on the bone plates occurred from archaeological excavation conducted at Tamiryn Ulaan Khoshuu, located in Ogiinuur soum of Arkhangai aimag. The paper focuses on the bone bow plates discovered from burial 36, as well as the artifacts excavated in 2022 from burial 67 and 74. The line imagery depicted on these artefacts are examined in comparison with previously known bone bow plates, with the aim to identify its unique features and highlighting variations in representational style.

Keywords: Bone bow plates, line-art imagery, Xiongnu mortuary archaeology

Ном зүй

Legrand-Pineau, A., Sidéra, I., Buc, N., David, E., Scheinsohn, V., Campana, D., Choyke, A., Crabtree, P., Stone, E., & Vass, L. (2018). Bone-working in Roman Dacia.

Амгалантөгс, Ц., & Амартүвшин, Ч. (2005). Нумын наалтан дээрх сараачмал хэдэн дүрс. *Studia Archaeologica*, (III) XXII(5).

Базарсүрэн, Ж. (2000). Чингис хааны цэргийн зэр зэвсэг (Д. Цэвээндорж (ed.); 1st ed.). Алтан үсэг.

Батсайхан.З. (1992). Хүннү нумын хийцийн тухай. *Studia Archaeologica*, XIII(7), 69–77.

Мөнхдэлгэр, Г. (2010). Монгол нум сум. МУИС.

Очир, А., & Чен, Ж. Ё. (2015). Их талын нүүдэлчид ба торгоны зам (1st ed.).

Төрбат, Ц., Амарбилэг, Ч., & Энхбаяр, Б. (2022). “Тамирын голын Хүннүгийн эрдэнэс” төслийн хээрийн шинжилгээний ангийн 2022 оны ажлын тайлан.

Төрбат, Ц., Амарбилэг, Ч., Энхбаяр, Г., Золжаргал,

А., Ундрал, Б., & Билгүүн, Э. (2022). “Тамирын голын хүннүгийн эрдэнэс-2” төслийн хээрийн шинжилгээний ажлын товч үр дүн. In Д. Хатанбаатар & Л. Эрдэнэболд (Eds.), *Монголын Археологи* (pp. 82–85). Мөнхийн үсэг.

Төрбат, Ц., Батсүх, Д., & Бемманн, Я. (2015). Монгол Алтайн Өвөр бэлийн Авын Хөх Уулын Хүннүгийн булш. *Studia Archaeologica*, XXXV(20), 295–323.

Төрбат, Ц. (2021). Тамирын Улаан хошууны 2017 оны олдворын судалгаа. - Тамирын Улаан хошууны хүннүгийн соёл. Редактор Ц.Төрбат, Э.Крюбезы. УБ.

Received: Nov. 10, 2025; Revised: Dec. 11, 2025; Accepted: Dec. 23, 2025

